



ТЭНГЭРЛИГ

МЕДИА ГРУПП

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК
УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

ХУРЛЫН ЗАР

Тэнгэрлиг Медиа ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 дугаар 18-ны өдрийн тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

ХЭЗЭЭ: 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт live.tngr.media-аар дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ОНООСОН НЭР: ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах;
2. 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын
3. дүгнэлтийг танилцуулах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох;
5. Компанийн оноосон нэрийг өөрчлөх;
6. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
7. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах;
8. Бусад асуудал;

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

ХУРАЛД БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;

Хувьцаа эзэмшигч та ажлын өдрүүдэд 9:00–13:00, 14:00–18:00 цагийн хооронд доорх газруудад хандаж хурлын материал, саналын хуудастай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компанийн байр
- Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байр, 2 давхарт байрлах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК;
udval@tngr.media мэйл хаяг; Компанийн вебсайт: tngr.media

Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингсын байр, 2 давхар хаягаар “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-д шуудангаар явуулах боломжтой. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2022 оны 4 сарын 28-ны өдрийн 14:00 цаг байна.

Холбоо барих хүний нэр: А.Удвал

И-Мэйл хаяг: udval@tngr.media

Утас: 89074970

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

№22/03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам", Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр [/live.tngr.media/](https://live.tngr.media/) зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтын дагуу тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
7. Хурлын даргаар Г.Уянгыг томилсугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга:
"Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
"Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Д.Бат-Оюун
“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал
Б.Батзаяа

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
Үүнд:

Тооллогын комиссын дарга:

“Блүмсбюри секьюритис ҮЦК” ХХК-ийн Г.Алтансүх

Тооллогын комиссын гишүүд:

“Блүмсбюри секьюритис ҮЦК” ХХК-ийн Р.Тогтохбаатар

“Блүмсбюри секьюритис ҮЦК” ХХК-ийн Б.Ариунзул

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА



Г.УЯНГА

ХУРЛЫН ДЭГ

Хэлэлцэх асуудал	Хугацаа	
Хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээлэх	11:00-11:10	Тооллогын комиссын дарга Г.Алтансүх
Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	11:10-11:15	Хурлын дарга Г.Уянга
Хэлэлцэх асуудал <ul style="list-style-type: none">Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах;2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулахТөлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох;Компанийн оноосон нэрийг өөрчлөх;Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах;Бусад асуудал.	11:15-12:15	Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ ТУЗ-ийн гишүүд
Асуулт, хариулт, санал хураалт	12:15-12:25	Хурлын дарга Г.Уянга Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ
Хурлын завсарлага, санал тоолох	12:25-12:35	Тооллогын комисс
Тооллогын комиссын тогтоол танилцуулах	12:35-12:40	Тооллогын комиссын дарга Г.Алтансүх
Хурлаас гарах тогтоолыг танилцуулах	12:40-12:45	Тооллогын комиссын дарга Г.Алтансүх
Хурлыг хаах	12:45-13:00	Хурлын дарга Г.Уянга

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран зүтгэгчид та бүхэнд 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж байна.

ТэнГэрЛиг Медиа Групп ХК (MSE: TNGR) нь Монголын Хөрөнгийн Бирж дээр үйл ажиллагаа явуулж байсан “Е-Моние” ХК-тай урвуу нэгдэл хийх замаар нээлттэй компани болж үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн. Цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа эхлүүлсэн хэдий ч маш амжилттай бөгөөд хурдтайгаар ажиллан өнгө төрхөө тодорхойлж, бүтэн брэндинг хийн, www.tngr.media албан ёсны вэбсайтаа хийсний сацуу хаалттай хүрээнд 5,941,457 хувьцаа нэмж гаргах зөвшөөрлөө Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №344 тоот тогтоолоор авч, тус компанийн нийт хувьцаа 6,000,000 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсныг энд онцлууштай.

Ингэснээр ТэнГэрЛиг Медиа Групп ХК нь хөрөнгө оруулагчдынхаа тоог нэмэх, мөн хувьцаагаа арилжаалж эхлэх боломжтой болсон бөгөөд энэ нь хэвлэл мэдээллийн салбарт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүжилт татах, ил тод байдлыг хангах, бизнесийн тогтвортой, хараат бус моделийг бий болгон энэ салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгод нь томоохон дэмжлэг болно хэмээн үзэж байна.

Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн хувьцаа 14 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэн, оны эцэст 20,000 төгрөгөөр хаагдаж, 2021 онд хувьцаа эзэмшигчдийн тоо 428-аар нэмэгдэн 556 болсон. Нэгж хувьцааны хамгийн дээд ханш 36,700 төгрөг хүрсэн нь анх зарласан 2179 төгрөгөөс даруй 1,585% хувийн өсөлт үзүүлсэн байгаа юм. Тэнгэрлиг Медиа Групп ХК нь 2021 оны эцсийн байдлаар нийт 29 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 5 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна. Компанийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахтай холбоотойгоор 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн 22/02 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан.

Компанийн хувьд уламжлалт болон дижитал медиа, ОТТ, технологийн инноцавиудыг нэгтгэж, хүн бүрт контентийн боломжит бүх төрлөөр, төхөөрөмжид үл хязгаарлагдан хүрэхээр зорьдог бөгөөд цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, зах зээлийг томсгон, үр нөлөөг ихэсгэж, түүгээрээ дамжуулан нийгмийг эерэг өөрчлөлтөд хөтлөх зорилготой ба 2022 онд уг зорилтуудын хүрээнд хэвлэл мэдээлэл, контентын зах зээлд ихээхэн нөлөө үзүүлэх төслүүдийг бэлэн болгож, шаардлагатай салбар, агентлаг, компани, платформуудад хөрөнгө оруулалт хийн ажиллах үүргийг Гүйцэтгэх удирдлагад даалган хариуцууллаа.

ТУЗ нь улирал бүр компанийн дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөөт ажлуудын үр дүнг хэлэлцэж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх, санал, шүүмжлэл хэлж, засаж залруулж ирсэн. Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин ажиллах болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн тусдаа санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх тусдаа санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, тусдаа өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, “Тусдаа санхүүгийн тайлан” (НББОУС 27)-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Асуудлыг онцлох нь

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулга 6.13, өөрийн хөрөнгө буюу хувьцаа эзэмшигчдийн өмчийн өөрчлөлт, үлдэгдэл, ажил гүйлгээнд анхаарлаа хандуулна уу. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн эцсийн өмчлөгчийн өөрчлөлт, ажил гүйлгээний нөлөөллөөс хамааран хувьцаат компанид үүсч болох эрсдлийн талаар дурдсан ба зарим онцлох тайлбарыг доор оруулсан болно. Бид энэхүү асуудлаар аудитын дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

2021 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн багцын арилжаагаар “Ард Менежмент ҮЦК” ХХК нь “Е-Монис” ХК (хуучин нэр)-ийн 52,925 ширхэг хувьцааг худалдан авч тус компанийн нийт энгийн хувьцааны 90.4 хувийн эзэмшигч болсон.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Е-Моние” ХК-ийн шинэ Хувьцаа эзэмшигчдийн хурлын 21/04 тоот тогтоолоор компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлан компанийн оноосон нэрийг “Тэнгэрлиг медиа групп” ХК болгон өөрчилж 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн ба 5,941,457 ширхэг энгийн хувьцааг СЗХ-ны даргын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 343 тоот тогтоолоор нэмж гарган нийт энгийн хувьцааны тоог 6,000,000 ширхэгт хүргэсэн. Нэмж гаргасан энгийн хувьцааг 4 нэр бүхий стратегийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгож эзэмшүүлсэн. Эдгээр хөрөнгө оруулагч нар нь өөрсдийн эзэмшлийн хувьцааг гэрээний 5 нэр бүхий компанийн энгийн хувьцаагаар солилцсоны үр дүнд “Тэнгэрлиг медиа групп” ХК нь “Про медиа нетворк” ХХК болон “Анрид” ХХК гэсэн охин компаниудыг эзэмшдэг толгой компани болсоныг аудитын явцад танилцсан.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд анхаарал хандуулахуйц аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Тусдаа санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь НББОУС 27, Тусдаа санхүүгийн тайлан (НББОУС 27)-ын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ. Компанийн гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тусдаа тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол тусдаа санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол тусдаа санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Тусдаа санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Тусдаа санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид гүйцэтгэх удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид гүйцэтгэх удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Гүйцэтгэх удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайланг хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Тэнгэрлиг медиа групп" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2022 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 28-НЫ ӨДӨР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тодруулга	2021.12.31.	2020.12.31.
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6.1	1,221,210.6	1,926.3
Худалдааны ба худалдааны бус авлага	6.2	1,363,103.5	
Зээлийн хүүний авлага	6.3	12,817.8	
Урьдчилж төлсөн зардал	6.9	47,105.6	
Эргэлтийн хөрөнгийн дүн		2,644,237.5	1,926.3
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.10	2,543.6	5,000.0
Бусад олгосон зээл	6.3	700,000.0	
Хөрөнгө оруулалт	6.4	13,131,084.8	
Бусад эргэлтийн бус хөрөнгө	6.5	13,285,440.0	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		27,119,068.4	5,000.0
НИЙТ ХӨРӨНГӨ		29,763,305.9	6,926.3
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Худалдааны ба худалдааны бус өглөг	6.6	107,293.0	5,500.0
Татвар, шимтгэлийн өр	6.11	140,386.6	
Богино хугацаат зээл	6.7	363,331.6	
Зээлийн хүүний өглөг	6.7	8,913.7	
Богино хугацаат өр төлбөрийн дүн		619,924.9	5,500.0
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	6.7	1,066,668.4	
Бусад урт хугацаат өглөг	6.8	2,302,180.1	
Хойшлогдсон татварын өр төлбөр	6.12	1,241,280.0	
Урт хугацаат өр төлбөрийн дүн		4,610,128.5	
Нийт өр төлбөр		5,230,053.4	5,500.0
Өөрийн хөрөнгө			
Хувийн өмч – Энгийн хувьцаа	6.13	599,145.7	5,000.0
Нэмж төлөгдсөн капитал	6.13	12,352,289.1	
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6.13	11,171,520.0	
Хуримтлагдсан ашиг	6.13	410,297.7	(3,573.7)
Нийт өөрийн хөрөнгө		24,533,252.5	1,426.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		29,763,305.9	6,926.3

Баталсан:



Г. Бат-Эрдэнэж

Гүйцэтгэх захирал

Д. Бат-Оюун

Санхүү эрхэлсэн захирал

А.Удвал

Нягтлан бодогч

"BAKER TILLY DALAIYAN AUDIT" L
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн сэтгэлийн хэсэг болно.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тодруулга	2021.12.31.	2020.12.31.
Борлуулалтын орлого		-	-
Борлуулалтын өртөг			
Нийт ашиг		-	-
Борлуулалт, маркетингийн зардал	6.16	(7,024.0)	
Ерөнхий ба удирдлагын зардал	6.16	(1,099,782.5)	
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)		(1,106,806.5)	-
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	6.15	906,437.0	
Санхүүгийн ашиг, (алдагдал) цэвэр	6.14	660,406.8	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		460,037.3	
Орлогын татварын зардал	6.17	(46,165.9)	
Татварын дараах ашиг (алдагдал)		413,871.4	-
Бусад дэлгэрэнгүй орлого	6.18	11,171,520.0	-
Нийт дэлгэрэнгүй орлого		11,585,391.4	-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /тогрог/		268.07	-

Баталсан:



Г. Бат-Эрдэнэ

Гүйцэтгэх захирал

Д. Бат-Оюун

Санхүү эрхэлсэн захирал

А.Удвал

Нягтлан бодогч

"BAKER TILLY DALAYAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Хэвлэгдсэн тайлбар тодруулга нь энэ түү тайлангийн сэтгэж тэгжэ болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

Үзүүлэлт	Хувьцааг капитал	Нэмж төлөгдсөн капитал	Өмчийн эхийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
	5,000.0			(3,573.7)	1,426.3
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл					
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
Зарласан ногдол ашиг					
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000.0			(3,573.7)	1,426.3
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	594,145.7	12,352,289.1		413,871.4	413,871.4
Өмчид гарсан өөрчлөлт					12,946,434.8
Бусад дэлгэрэнгүй орлого			11,171,520.0		11,171,520.0
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	599,145.7	12,352,289.1	11,171,520.0	410,297.7	24,533,252.5

Баталсан:
Г. Бат-Эрдэнэ



Д. Бат-Оюун

Санхүү эрхэлсэн захирал

А.У.Двал

Нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал

"BAKER TILLY DALAYAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Давсардагдсан тайланг шалруулж нь зөвхөн тайлангийн голын зүй хэсэг болно

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2020.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн /+/</i>	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
<i>Мөнгөн зарлагын дүн /-/</i>	(236,098.1)	-
Ажиллагадад төлсөн	(110,195.0)	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(23,401.2)	
Татварын байгууллагад төлсөн	(5,587.8)	
Бусад мөнгөн зарлага	(96,914.1)	
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(236,098.1)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн /+/</i>	3,032,178.5	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,032,178.5	
<i>Мөнгөн зарлагын дүн /-/</i>	(2,852,879.9)	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(2,879.9)	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(50,000.0)	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(2,800,000.0)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	179,298.6	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн /+/</i>	1,464,700.0	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,464,700.0	
<i>Мөнгөн зарлагын дүн /-/</i>	(188,616.3)	-
Зээл, урьдчилгаанд төлсөн мөнгө	(187,616.3)	
Төрөл бүрийн хандив	(1,000.0)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,276,083.7	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,219,284.2	-
Валютын ханшийн зөрүү	0.1	
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	1,926.3	1,926.3
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	1,221,210.6	1,926.3



Д. Бат-Оюун

Санхүү эрхэлсэн захирал

А.Удвал

Нягтлан бодогч
 "BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
 CERTIFIED ACCOUNTING, AUDITING
 & APPRAISAL

Хамсарсан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШИГЧИД

ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

<p>Галням Уянга</p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none">• 2002 Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Банк санхүү• Хартфорт дээд сургууль, MBA <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none">• 2019 Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал• 2009 Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал• 2005 Грасрүүтс жижиг дунд бизнес дэмжих төв (НҮБ-ийн төсөл), Захирал
<p>Ганхуяг Бат-Эрдэнэ</p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none">• 2006 Улс төр нийгэм судлал, Зүүн Англи Норвичийн Их Сургууль• 2016 Удирдах албан тушаалтны хөтөлбөр, Харвард Бизнесийн сургууль <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none">• Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал• Монголын телевизүүдийн холбоо, УЗ-ийн дарга• Монгол Телевиз ХХК, Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал• Номсис ХХК, Ерөнхий захирал
<p>Нармандах Мөнхнасан</p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none">• 2003 Санхүү эдийн засгийн удирдлага, Сан Францискогийн их сургууль• 2008 Санхүүгийн инженер Магистр, Жорж Вашингтон их сургууль <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none">• Монполимет Групп, ТУЗ-ийн дарга• Дэлхийн банк төв оффис АНУ, Монгол улсыг хариуцсан эдийн засагч• Монголбанк, Эдийн засагч• ANN ХХК, Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

**Чинбат
Батхүү**



Боловсролын байдал

- 2011, Олон улсын харилцаа, Loughborough University

Ажилласан байдал

- Брикланд ХХК, Ерөнхий захирал

**Амарсайхан
Ундрал**



Боловсролын байдал

- 2008 Эдийн засаг МУИС
- 2018 Менежмент магистр, Львений Их сургууль

Ажилласан байдал

- ТэнГэр Телевиз, Гүйцэтгэх захирал
- Анрид ХХК, Гүйцэтгэх захирал
Монголын үндэсний олимпийн хороо, Нарийн бичгийн даргын орлогч
- UBS Телевиз, сэтгүүлч, редактор

**Батбилэг
Золбоо**



Боловсролын байдал

- 2013 Олон улсын нягтлан бодох бүртгэл, СЭЗИС
- 2016, Эдийн засагч, Plattsburgh коллеж

Ажилласан байдал

- Ард Санхүүгийн Нэгдэл, Санхүү эрхэлсэн захирал
- Ард Менежмент, Гүйцэтгэх захирал
- Ард Менежмент, Хөрөнгө оруулалтын шинжээч
- Ард Секьюритиз ҮЦК, Хөрөнгө оруулалтын шинжээч

ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

<p>Ванчиг Ганзориг</p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none">● 2001 Бизнесийн удирдлага, ХҮДС● 2005 Бизнесийн удирдлага мастер, Австрали Нотр Дэймийн их сургууль● 2010, Цахим бизнесийн удирдлага мастер, Японы олон улсын их сургууль <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none">● BSP, УЗ-ийн дарга● Медиа Групп, Гүйцэтгэх захирал● Шунхлай Групп, Стратеги хариуцсан захирал
<p>Нацагдорж Цогт</p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none">● 1994 Москва АХДС● 2005 Хамлын их сургууль <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none">● Үндэсний хөгжлийн газар, Мэргэжилтэн● Хууль Зүйн Дотоод Хэргийн Яам, Ахлах мэргэжилтэн● Бона лекс хуулийн товчоо, Хуульч захирал
<p>Бадрууган Наранзун</p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none">● 1997 Монгол Улсын Их Сургууль <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none">● Лето Мьюзик ХХК, Гүйцэтгэх захирал● АПУ ХК, ОНХХ хариуцсан захирал● АПУ ХК, ХН хариуцсан захирал● Шунхлай Групп, ОНХХ хариуцсан захирал

ХАВСРАЛТ



ТЭНГЭРЛИГ

МЕДИА ГРУПП

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
03 дугаар сарын 18-ны өдрийн 22/03
тоот тогтоолын Хавсралт 1

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах;
2. 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох;
4. Компанийн оноосон нэрийг өөрчлөх;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах;
7. Бусад асуудал;

**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт цахимаар хуралдах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2022 оны сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт цахимаар хуралдах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигч

№	Ердийн гишүүдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	Галням Уянга	
2	Нармандах Мөнхнасан	
3	Чинбат Батхүү	
4	Амарсайхан Ундрал	
5	Батбилэг Золбоо	
6	Ганхуяг Бат-Эрдэнэ	

ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигч

№	Хараат бус гишүүний нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	Бадрууган Наранзун	
2	Нацагдорж Цогт	
3	Ванчиг Ганзориг	

Санамж. Хувьцаа эзэмшигч та кумулятив аргаар саналаа өгөхдөө доорх зааварчилгааг анхааралтай уншина уу. Саналын тоогоо илүү эсвэл буруу өгсөн тохиолдолд таны саналын хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч та “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн хараат бус гишүүн байхаар тогтоосон.

Таны эзэмшиж буй 100 ширхэг хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд 900 (100*9=900) болох ба үүнээс 600 саналын эрхээрээ ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч та саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2022 оны сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт цахимаар хуралдах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн оноосон нэрийг өөрчлөх			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2022 оны сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт цахимаар хуралдах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2022 оны сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ХЭ-22/01

Улаанбаатар хот

**Компанийн 2021 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлан батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15, 62.1.16 дахь заалт болон 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 22/... тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ХЭ-22/02

Улаанбаатар хот

Г Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд Г
ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 22/... тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд сонгон томилсугай. Үүнд:
Ердийн гишүүдээр:

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.
- 6.

Хараат бус гишүүдээр:

- 7.
- 8.
- 9.

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ХЭ-22/03

Улаанбаатар хот

Г *Компанийн оноосон нэрийг өөрчлөх* Г
тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 22/... тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн оноосон нэрийг дараах байдлаар өөрчилсүгэй:
 - а) Бүтэн нэр: “Тэнгэрлиг Медиа Нэгдэл” ХК

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ХЭ-22/04

Улаанбаатар хот

**Компанийн дүрмийн шинэчилсэн
найруулгыг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 22/... Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрэмд оноосон нэрийн өөрчлөлтийг оруулж хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг албан тушаалтай..... овогтой-нд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА